



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн байгууллагаас гаргасан 2019 оны зун, намрын цаг агаарын урьдчилсан төлөв байдлаар 07-09 дүгээр саруудад дуу цахилгаантай аадар бороо, мөндөр орох, борооны үеэр салхи 12-14м/с, зарим үед 16-18 м/с хүрэн ширүүсч, аюулт үзэгдэл болох, салхи ширүүссэн үед гал түймэр гарч болзошгүй тул үер усны аюул, усны осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг, анхны тусламж үзүүлэх чадвар олгох танхимын сургалтыг гамшгаас хамгаалах “Бэлэн бай” сургалтын багцаар 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд хороодын Иргэний танхимд зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 8.058.000 (найман сая тавин найман мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Удирдамж, хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулж илтгэх хуудсыг оролцогчдын нэр, гарын үсгийн хамт 07 дугаар сарын 08-ны өдөр Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст ирүүлэхийг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт, сургалтын явцад хяналт тавьж, дүнг танилцуулахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН



1117155601
УХ00038 9077073
ҮЕР УСНЫ АЮУЛ, ОСОЛ, ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

2019 оны зун намрын цаг агаарын урьдчилсан төлвөөр 7-9 дүгээр саруудад дуу цахилгаантай аадар бороо, мөндөр орох, салхи ширүүсэх зэргээр аюулт үзэгдэл тохиолдож болзошгүй тул ард иргэдэд үер усны аюул, усны осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг, анхны тусламж үзүүлэх чадвар олгоход оршино.

Хоёр. Сургалт зохион байгуулах хугацаа, байршил

2019 оны 06 дугаар сарын 28-наас 07 дугаар сарын 05-ны хооронд хороодын Иргэний танхимд зохион байгуулна.

Гурав. Сургалтанд хамрагдах бүрэлдэхүүн

Сургалтыг дүүргийн үерийн эрсдэлтэй бүсэд байрлах байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, иргэд 2019 оны эхний хагас жилд объектын гал түймрийн дуудлага их гарсан хороодын хэсгийн ахлагч, иргэдийг хамруулж зохион байгуулна. Үүнд:

д/д	Дүүрэг	Сургалтанд хамруулах иргэний тоо
1	Багануур дүүрэг	50
2	Багахангай дүүрэг	20
3	Баянзүрх дүүрэг	80
4	Баянгол дүүрэг	50
5	Налайх дүүрэг	50
6	Сонгинохайрхан дүүрэг	80
7	Сүхбаатар дүүрэг	80
8	Хан-Уул дүүрэг	80
9	Чингэлтэй дүүрэг	50
Нийт		540

Дөрөв. Зохион байгуулах бүрэлдэхүүн

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, орлогч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар хамтран зохион байгуулна.

Сургалтын явц, үр дүнд Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллана.

Тав. Сургалтын хөтөлбөр

Эхлэх дуусах цаг	Сэдэв	Ноогдох хугацаа	Хариуцах албан тушаалтан
------------------	-------	-----------------	--------------------------

08:45-09:00	Бүртгэл	15 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
09:00-09:30	Гамшгийн тухай ерөнхий ойлголт /"Бэлэн бай" сургалтын багцын "Гамшгийн тухай ойлголт" хичээлээр/	30 минут	Дүүргийн ОБХ-ийн орлогч, ГХТББХАМ, ахлах байцаагч
09:30-10:00	Нийслэлд гарч байгаа гамшиг осол, гал түймрийн шалтгаан нөхцөл, эрсдэлийг бууруулах арга хэмжээ	30 минут	Дүүргийн ОБХ-ийн Эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
10:15-11:00	Үер, усны аюул, гол усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ /олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох "Бэлэн бай" сургалтын багцын "Үер" сэдвээр/	60 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
11:00-11:15	Цайны завсарлага	15 минут	ОБХ-ээс томилогдсон алба хаагч
11:15-12:00	Галын аюулгүй байдлын тухай хуулиар аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, иргэний хүлээсэн үүрэг	45 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч
12:00-12:30	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн талаарх ойлголт, гал унтраагуурыг хэрхэн ашиглах талаар	30 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч
12:30-13:30	Үдийн хоол	60 минут	ОБХ-ээс томилогдсон алба хаагч
13:30-14:30	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ /"олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох "Бэлэн бай" сургалтын багцын "Гал түймэр" сэдвээр/	60 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
14:30-16:00	Анхны тусламжийн хичээл /живэх, түлэгдэх, хэт халалтын шокын үеийн анхны тусламж, зүрх уушгины сэхээн амьдруулалт/ "Бэлэн бай" сургалтын багцаар	90 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
16:00-16:15	Цайны завсарлага	15 минут	Томилогдсон алба хаагч
16:15-17:00	Сургалтын дүгнэлт ярилцлага, хаалт	45 минут	Сургалтанд оролцогчид

Зургаа. Тайлан мэдээ ирүүлэх

Сургалтын явцын гэрэл зураг бүхий илтгэх хуудсыг оролцогчдын нэрс, гарын үсгийн скайнердсан хувийн хамт файлаар 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст nobg.surgalt@gmail.com хаягаар ирүүлнэ.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
А/66 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117155601

ҮЕР УСНЫ АЮУЛ, ОСОЛ, ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт /төгрөг/
а.Хоол, цайны зардал:					
1	Хоол	ш	6.500	540	3.510.000
2	Кофе	ш	300	1080	324.000
3	Печень, цайны боов	ш	500	1080	540.000
4	1 удаагийн аяга	ш	150	1080	162.000
Хэсгийн дүн					4.536.000
б.Бичиг хэргийн зардал:					
5	Дэвтэр	ш	1000	540	540.000
6	Бал	ш	800	540	432.000
Хэсгийн дүн					972.000
в.Тараах материал хэвлүүлэх зардал:					
7	Санамж: "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлье" Хэмжээ: 105х297мм	ш	170	7500	1.275.000
8	Сэрэмжлүүлэг "Усны ослоос урьдчилан сэргийлье" Хэмжээ: 105х297мм	ш	170	7500	1.275.000
Хэсгийн дүн					2.550.000
Нийт					8.058.000